

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2020 оны 1 дүгээр сард 1 удаа хуралдаж, аймгийн ИТХ-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн нутаг дэвсгэрээс 2020 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны дээд хязгаар тогтоох тухай, Албан тушаалын тодорхойлолт батлах тухай, Аймгийн ИТХ-ын ажлын албаны орон тоо, бүтэц, ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлах тухай, Төрийн цол одон медалиар шагнуулахаар тодорхойлох зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөний төслийг зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулж, салбар зөвлөлийн гишүүд төлөвлөгөөний төсөлтэй танилцаж төлөвлөгөөг нягталж, дараагийн хуралдаанаар батлуулахаар шийдвэрлэв.

Монгол Улсын Үндсэн хууль баталсны 28 жилийн ойд зориулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас санаачлан, Баян-Өлгий аймгаас Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулиар депутатаар сонгогдон, шинэ Үндсэн хуулийг батлалцсан Ардын их хурлын депутатуудын буланг аймгийн Музейд байршуулж, түүх намтар, зургийн хамт хадгалууллаа.

Мөн аймгаас АИХ-ын депутатаар сонгогдож Үндсэн шинэ хуулийг батлалцсан депутатуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэв.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөн олговор олгох 2 хүний материалыг ЦАУЗБУК-т хүргүүлэн ажиллав.

Аймгийн ИТХ-д иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс 37 аялал бичиг, 20 өргөдөл хэргэлт ирсэн бөгөөд аймгийн ИТХ-аас 23 аялал албан бичиг явуулж, иргэдийн биечлэн болон бичгээр өргөдөл, хэргэлтийг холбогдох газарт уламжилж, шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэсэн байна.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн энэ сард нийт 5 удаа хуралдав. Уг хуралдаанаар аймгийн удирдлагууд тус аймагт долоо хоногт болж өнгөрсөн үйл ажиллагаануудын талаар танилцуулж, хэлтэс, агентлагийн удирдлагуудын хэрэгжүүлсэн ажил, санал, хүсэлтийг сонсож, цаг үеийн асуудлаар нийт 36 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан Засгийн газрын 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн сурагчдын амралтыг 7 хоногоор сунгаж, орон нутгийн сурагчдын амралтыг аймгийн Засаг дарга нь зохицуулалт хийхээр шийдвэрлэсэнтэй холбоотой 1 дүгээр сарын 10-ны өдөр тус аймгийн Онцгой комисс хуралдаж томуу томуу төст өвчний дэгдэлт их байгаа учраас сургууль болон цэцэрлэгийн өмчийн бүх хэлбэр харгалзахгүй амралтыг долоо хоног сунгах шийдвэр гаргав. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 01-р сарын 10-ний өдрийн А/17 тоот захирамж гарч, тус аймагт хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлав.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, батлан хамгаалах төрийн үйлчилгээг ард иргэдэд нээлттэй, шуурхай хүргэх арга хэмжээг аймаг, орон нутагтаа чадварлаг зохион байгуулж, 2019 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо онц сайн биелүүлсэн амжилтаар 2019 оны Монгол Улсын тэргүүний Цэргийн штабаар шалгарав.

ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Саулегээр ахлуулсан ХХААХҮЯам, Онцгой байдлын Ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг Өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, цаг хүндэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлын талаар үүрэг чиглэл өгөх үүднээс 1 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт ажиллав.

Тэрээр 1 дүгээр сарын 17-ны өдөр аймгийн Онцгой комиссыг хуралдуулж өвөлжилтийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсов. Баян-Өлгий аймгийн хувьд одоогоор өвөлжилт хэвийн, өвөлжилт хүндрээгүй учраас аймаг болон сумын аюулгүйн нөөцөөс өвс тэжээл олгоогүй байна. Мөн малын зүй бус хорогдол гараагүй, ихэнх нутгаар цасан бүрхүүл тогтсон, Булган, Ногооннуур, Сагсай, /Даян/ Цэнгэл сумдад цасны зузаан 1-8 см, уулаараа 10-15 см зузаан байна. Мөн 2019-2020 оны өвөл нийт 172 өрхийн 69519 толгой отроор өвөлжиж байгааг албаны хүмүүс мэдээллээ.

Цаашид цаг агаар хүйтэрч, хүндрэх төлөвтэй байгаа учраас болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, отроор өвөлжиж буй малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэх, цаг хүндэрсэн үед шат дараатай арга хэмжээ авч ажиллахыг ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле холбогдох хүмүүст анхаарууллаа.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Эрүүл мэндийн сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсаны дагуу алслагдсан орон нутгийн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн салбарын парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймгийн Баяннуур, Бугат сумдын эрүүл мэндийн төвүүд Фургон маркын түргэн тусламжийн автомашинтай боллоо.

Түргэн тусламжийн авто машиныг 1 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргал аймгийн Засаг дарга А.Гылымханд гардуулж, хүлээлгэн өглөө.

Ийнхүү сүүлийн 3 жилийн хугацаанд тус аймгийн эрүүл мэндийн салбар нийт 22 авто машинаар парк шинэчлэлт хийж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, бүх сумын Эрүүл мэндийн төв түргэн тусламжийн автомашинаар бүрэн хангагдан иргэдэд эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломж бүрдлээ.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зориулж эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, баримтлах бодлогын талаар нэгдсэн ойлголт өгөх, чиг үүргийг нь тодорхойлох зорилго бүхий семинарыг энэ сарын 21-ээс 24-ний өдрүүдэд Төрийн ордонд зохион байгууллаа.

Энэ хуралдаанаар Засгийн газрын гишүүд хариуцсан салбарынхаа бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өгч, хамтран ажиллах, тулгамдсан асуудлыг нь шийдэх боломжийн талаар ярилцаж харилцан санал солилцов.

Хуралдааны дараа ЗГ-ын гишүүд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулж гарын үсэг зурсан болно.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн хуралдаанаар Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сангийн он дамжсан 1,7 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, тус аймгийн 8184 иргэн Нийгмийн халамжийн сангаас авч чадаагүй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтөө авах нөхцөл бүрдэв.

Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдацтай тархаж байгаатай холбогдуулан 1 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Онцгой комисс хуралдаж, шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх асуудлыг хэлэлцэж, аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 27-ний өдрөөс эхлэн 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд харах төв, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, олон нийтийг хамарсан хурал, жагсаал цуглаан, сургалт, баяр ёслол, хурим, найр, уралдаан, тэмцээн, секц, дугуйлан зохион байгуулах, цахим тоглоом ажиллуулахыг хориглолоо.

Мөн хуралдаанаар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангах, Хилийн боомтын хяналтыг сайжруулах, тандалт судалгааг эрчимжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга замыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон албан байгууллагаар дамжуулан эцэг, эх, асран хамгаалагч нарт чиглэл, зөвлөмж өгч ажиллах, Бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх зэрэг асуудлуудыг хэлэлцэж холбогдох байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосон.

Шинэ төрлийн коронавирусын халдвараас "Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх" тухай аймгийн Засаг даргын 2020 оны 01-р сарын 27-ний өдрийн А/44 тоот захирамж, Шинэ Корона вирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чиглэлээр А/02 тоот албан даалгавар тус тус гарч аймгийн Засаг даргын захирамж, мөн Үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх тухай аймгийн Засаг даргын зөвлөмж болон Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн мэдэгдлийг аймагт үйл ажиллагаа явуулдаг 85 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2020 оны 01-р сарын 27-ний өдрийн А/44 тоот захирамжийг үндэслэн томуу, томуу төст өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүд, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, Дээд боловсролын байгууллагууд, Номын сан, кинотеатр, соёл, урлаг, хурим найрын үйлчилгээний газрууд, Спортын тэмцээн, уралдаан зохион байгуулах газрууд, Жолооны курс, Мэргэжлийн түр сургалтын байгууллагууд /бүх шатны сургалтын төвүүд, мэргэжил олгох түр сургалтууд, хэлний дамжаа, курс, хүүхдийн ордон, хүүхдийн урлан бүтээхийн дугуйлан г.м/, Интернет, цахим тоглоомын газрууд, Бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрууд, Өдөр өнжүүлэх төвүүд, Хүүхэд харах үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсоосон.

Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн цахимаар явуулж 1 дүгээр сарын 30-ны өдөр товлогдсон хугацаандаа дуусгасан ба 2 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн төрийн албаны ерөнхий шалгалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж, ерөнхий шалгалтын хугацааг хорио цээрийн дэглэм цуцалсны дараа дахин товлож зарлахаар болсонтой холбогдуулан ард иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан.

Энэ сард Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон 43 иргэний материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, материалыг холбогдох дээд газар, яаманд уламжлан ажилласан.

Мөн аймгийн төв болон сум, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авч танилцан, шагналын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох журмын дагуу аймгийн удирдлагуудад танилцуулан шийдвэр гаргуулж шагнуулсан. Үүнд шагналын болзлыг хангасан иргэдийг аймгийн “Хүндэт тэмдэг”, “Тэргүүний ажилтан”, Засаг даргын “Жуух бичиг” зэрэг шагналуудаар шагнасан болно.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас энэ онд тохиох аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтан "Аймгийн сүлд дуу" шалгаруулах уралдааны болзол зарлалаа.

1.2.1. Өргөдөл, гомдлын талаар

2020 оны 1 дүгээр сард аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 121 өргөдөл ирүүлснээс бичгээр 115, аймгийн ИТХ-аас 6 өргөдөл шилжүүлсэн байна.

Эдгээрээс 94 өргөдлийг хэлтэс, агентлагуудад шийдвэрлүүлэхээр уламжилсан, одоогоор шийдвэрлэх шатандаа явж байгаа ба 27 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэдэд хариу өгсөн болно.

Ирүүлсэн 121 өргөдлөөс:

- Ажил хүссэн 72
- Хүсэлт тавих тухай 12
- Гомдол 7
- Тусламж хүссэн 11
- Нэмэгдэл 9
- Эмчилгээний зардал хүссэн тухай 3
- Чөлөө 3
- Орон байр хүссэн тухай 1
- Тэтгэмж хүссэн тухай 1
- Цахилгаан шугам татуулах тухай 2 өргөдөл тус тус ирүүлсэн болно.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 56 ширхэг А захирамж, 6 ширхэг Б захирамжийг хянаж, тус буюу хууль тогтоомжийн лавлах санд хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгэж, иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээн авч, 5 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв. Мөн согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 7 дэлгүүр болон 3 үйлчилгээний газарт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар шинээр зөвшөөрөл олгов.

1.Архивын тасгийн мэдээ.

Иргэдээс 298 өргөдлийг хүлээж авч, 585 хадгаламжийн нэгжийг ашиглаж 295 лавлагаа, 1134 хуудас баримтыг хуулбараар олголоо.

Харилцагч байгууллагуудаас 22 албан бичиг ирснээс 14 хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, байгууллагуудад 31 албан бичиг хүргүүлж ажиллав.

Архивын тасгийн жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсвийн шууд захирагчаар хянуулж, батлуулав.

АЕГ-ын дэргэдэх Сургалтын төвд Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад зориулсан сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн нийт байгууллагуудын захиалгын маягтыг нэгтгэж 1 дүгээр сарын 15-ны өдөр АЕГ-т хүргүүлэхээр албан бичиг хүргүүлэв.

Сагсай, Алтай сумуудаас 2010-2018 оны мал тооллогын баримтыг хүлээн авлаа.

Байгууллагуудын Архив, албан хэрэг хариуцсан 12 хүнд зөвлөгөө өгөв.

Архивын тасгийн 2020 оны 1 дүгээр сарын байдлаар нийт цахимжуулсан баримтын мэдээг АЕГ-т сарын 25-ны өдөр хүргүүлэв.

Цахимд оруулсан 1 байгууллагын 30 хадгаламжийн нэгжийг үдэж хавтаслан 6 хадгаламжийн нэгжид сэлбэн засалт хийсэн.

2.1.2. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл /өссөн дүнгээр/

1	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгалт хувь	99,9
2	Шилжих хөдөлгөөн хот /шилжиж ирсэн аймаг хотоос/	29
3	Шилжих хөдөлгөөн хот дотор /сум, багаас/	1378
4	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	439
5	Шинээр гэрлэлт /тоо/	92
6	Нас баралтын бүртгэл	48
7	Төрсний гэрчилгээний бүртгэл	245
8	Үрчлэлт	8

2.2. Онцгой байдлын чиглэлээр

Энэ хугацаанд аймгийн Онцгой комиссын хурлыг 3 удаа хуралдуулж томуу, томуу төст өвчний дэгдэлт, БНХАУ-ын короновирусын талаар мэдээлэл сонсох, мал аж ахуйн өвөлжилтийн нөхцөл байдлыг ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын хэлтсийн дарга, дэд хурандаа Л.Тамир нараар ахлуулсан ажлын хэсэгт танилцуулан холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

Томуу, томуу төст өвчний дэгдэлт болон уушгины хатгалгааны хүндрэл эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн Онцгой комиссын шийдвэрээр аймгийн Засаг даргын 2020 оны А/17 дугаар захирамжаар 2019-2020 оны хичээлийн 2 дугаар улирлын амралтын үргэлжлэх хугацааг 7 хоногоор сунгаж, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 7 хоногоор хязгаарласан.

Онцгой байдлын газрын офицер бүрэлдэхүүний шуурхай хуралдааныг 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 96 офицер хамрагдаж 7 хоногийн төлөвлөгдсөн ажлын хэрэгжилтийн мэдээлэл сонсож, үнэлэлт дүгнэлт өгч, ОБЕГ-аас ирсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Энэ сард Газрын даргын 8 тушаал, 2 удирдамж гарснаас хүний нөөцтэй холбоотой 4, үйл ажиллагаатай холбоотой 4 тушаал гарч 100 хувь хэрэгжсэн.

ОБЕГ-аас 19, бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 24 нийт 43 албан бичиг, албан хаагчдаас 3, иргэдээс Галын аюулгүй байдлын дүгнэлт хүссэн 3, ажил хүссэн 1 өргөдөл хүлээн авч, Газрын даргын эрх хэмжээний хүрээнд бүрэн шийдвэрлэж ажиллаж байна.

ОБЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн 27 хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргэж, ОБЕГ-т 7, бусад байгууллага, аж ахуйн нэгжид 20 удаа албан бичиг хүргүүлэв.

Энэ сард Аймгийн хэмжээнд объектын гал түймрийн 4 удаагийн дуудлагатай байлаа. Үүнээс: Анги ажилласан-1, иргэд унтраасан-2, галын зөрчил-1 байна.

Дээрхи тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд нийт гал түймрийн тоо 1-ээр буюу 14,4 хувь буурсан үзүүлэлттэй байна.

	Дуудлагын тоо	Зарцуулсан			Хүч			Хугацаа			Аварсан			Хохирол	
		Шатахуун /л/	Хөөс /л/	Ус /тн/	1 тасаг	2 тасаг	2-оос дээш тасаг	30 минут	30-60 минут	60-аас дээш	Хөрөнгө /сая/	Байшин, гэр	Хүн	Том хүн	Хүүхэд
Нийт	4	15	-	0,3	1	-	-	1	-	-	500	1	-	-	-

2020 оны 01 дүгээр эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага -1 байлаа.

Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 6 дугаар багийн нутаг, “Даян нуур” гэдэг газар /аймгийн төвөөс баруун урд зүгт 178 км, сумын төвөөс баруун урд зүгт 148 “Стивр” /04-65БӨТ/ маркийн ачааны машинтай усанд живсэн тухай дуудлагыг 2019.12.01-ний өдрийн 05:30 цагт хүлээн авсан.

	Дуудлагын тоо	Шатахуун /л/	Хүч						Аварсан			Хохирол	
			ЭХАБ 1 тасаг	Бэлтгэл ээлж	Сумын мэргэжлийн	Техник	Хүн	Цаг	Хүн	Техник	Хөрөнгө/ сая/	Том хүн	Хүүхэд
Нийт	1	100	1	-	-	1	8	120	-	1	42,5	-	-

Улсын нөөцийн салбарт 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийлүүлэх 400 тн хорголжин тэжээлийг “Мегатитан” ХХК нь 100 хувь нийлүүлэн дуусгаж тэжээлийг орлогод авч акт, тэмдэглэл хөтөлж хувийг ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газарт хүргүүлэв.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Эрүүл мэндийн чиглэлээр

“Дербес”, “Саян” орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, орон нутгийн радиогоор дамжуулан Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, Урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдол, хавдраас урьдчилан сэргийлэх, А гепатитаас сэргийлэх, амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд чиглэсэн мэдээллийг 20 удаа өгсөн.

Хилийн цэргийн 0309 дүгээр заставт бүртгэгдсэн А гепатит өвчний 1 тохиолдлын дагуу ЭМГ-ын ажлын хэсэг өвчлөлийн голомтын эх уурхайд тандалт судалгаа, хяналт үнэлгээ хийж, А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж арга зүйгээр ханган 18 албан хаагч, цэцэрлэгийн насны 18 хүүхдүүдэд А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын эрүүл ахуй, вакцины ач холбогдол сэдэвт сургалт хийж, 18 хүнээс цусны сорьц авч, 3 хүүхдэд нөхөн дархлаажуулалт, 4 хүүхдэд тархвар судлалын заалтаар дархлаажуулалтад хамруулсан.

2020 оны аймгийн Засаг даргаар ахлуулсан Аймгийн Эрүүл мэндийн зөвлөлийн хурлыг нэг удаа зохион байгуулж, 80%-ын ирцтэй, 20 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн газраас А гепатит өвчин, угаарын хийн хордлого, орчны эрүүл мэнд, томуу томуу төст өвчний өнөөгийн байдлаар НЭМТөвийн мэргэжилтнүүд мэдээлэл хийсэн.

5 сургуулийн 52 багш нарт А гепатит, угаарын хийн хордлого, эрт илрүүлгийн үзлэгийн ач холбогдол сэдвээр сургалт явуулсан.

Манай аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар А гепатит өвчний нийт 10 шинэ тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн төвд 2, Улаанхус сумд 5, Буянт сумд 3 тохиолдол тус тус бүртгэгдэж А гепатитын голомтын тохиолдол бүрийн тандалт судалгааг дэлгэрэнгүй хийж ЭМС-ын А/527 тоот тушаалын дагуу А гепатит өвчний шаргүй далд хэлбэрийн үзлэгт хавьтлын 65 хүнийг хамруулж, эцсийн ариутгал, халдваргүйтгэлийг цаг тухайд нь хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажилласан.

Нэг айлын 6 хүн нүүрсхүчлийн хийгээр угаартсан ба Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт 5 хүний байдал хөнгөн 1 хүний байдал дунд байдалтай хүргэгдэж, хүмүүсийн биеийн байдлыг үнэлж, хүлээн авах тасагт эмчилгээ хийж, тандалт судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ЭМЯ-наас явуулсан “Шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчний үеийн халдварын сэргийлэлт хяналтын зөвлөмж,” Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлзүйн заавар болон Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай Аймгийн Засаг даргын 01, Шинэ коронавирүсээс сэргийлэх 02 албан даалгаврыг хүргүүлсэн.

ЭМЯ-наас зохион байгуулсан “Шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчний цахим хуралд Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ, ЭМГ-ын холбогдох 52 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан.

Аймгийн хэмжээний цэцэрлэгийн эрхлэгч нарт “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх, өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”, “ЭМС-ын 216 тоот тушаал”, “Халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл” сэдэвт сургалт хийж нийт 26 хүнийг хамруулсан.

2019 оны 4 улиралд гарсан 7 нярайн эндэгдэл, 3 жирэмсэн эхийн ноцтой хүндрэлийн тохиолдлын хурлыг зохион байгуулж, хурлын материалыг ЭМЯ-ны Хүүхэд

судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд тус тус хүргүүлэв.

ЭМЯ-д ЭМГ-ын 2019 оны гүйцэтгэлийн ХШҮ-ний тайланг хүргүүлсэн.

ЭМХТ-д ЭМГ-ын 2019 оны статистик мэдээллийн тайланг хүргүүлсэн.

ЭМС-ын 2017 оны А\422 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2017 оны А\369 дүгээр захирамжийн дагуу жилийн эцсээр тушаах холбогдох тайлангуудын хугацаанд ЭМЯ болон аймгийн ЗДТГ-ын холбогдох газар хэлтэст хүргүүлсэн.

3.2. Биенийн тамир, соёлын талаар

Казах үндэсний найрал хөгжмийн анхны удирдаач, Хөгжмийн зохиолч, МУ-ын гавьяат жүжигчин Ахмерийн Хавкей агсны нэр алдрыг мөнхжүүлэх, хойч үедээ өвлүүлэн таниулах зорилгоор 2020 оны 01-р сарын 18-ний өдөр уран бүтээлийн үдшийг зохион байгуулав.

“Ятгах тусам нягтал” аяны хүрээнд аймгийн Цагдаагийн газраас байгууллагын уран бүтээлч, ажилчдад аяны зорилго, ач холбогдлын талаар болон Залилах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, хор уршиг, үйлдлийн арга, хуулийн хариуцлага, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгууллаа.

Музейн стандартад заасны дагуу музейн сан хөмрөг дэхь үндсэн үзмэрүүдийг дүрс бичлэгтэй болгох ажил 50%- тай явагдаж байна.

Угсаатны зүйн үзүүлэлт байгаа үзмэрүүдийг Монгол-Англи хэлээр хаяг тайлбартай болгох ажил Үндэсний музейн мэргэжилтнүүдтэй хамтран хийгдэж дуусах шатандаа явагдаж байна.

Х.Ханипагийн нэрэмжит уншлагын танхимын номын санч тэтгэвэрт гарсантай холбоотой номын ээлжит бус тооллого хийж, ажил хүлээлцүүлэх акт бүрдүүлэн ажиллав.

Аймгийн 80 жилийн ойн баярт зориулж аймгийн зохиолчдын гар бичмэлийн архив байгуулах тухай удирдамж, төсөв, “Шилдэг номын сан” уралдаан, “Жигит султаны”, “Наурыз бике” уралдаан, “Номын сангийн өнөөгийн байдал” сэдэвт аймгийн болон сумдын номын санчдыг хамруулсан сургалтын хөтөлбөр тус тус боловсруулав.

2020 оны Аймгийн аварга шалгаруулах “Идэрчүүдийн гар бөмбөг”-ийн тэмцээн, “Тогыз хумалах”, “Цодгор хүү” өсвөр үеийн шатрын аврага шалгаруулах тэмцээнүүдийг зохион явууллаа.

ДӨРӨВ. ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.Хөдөө аж ахуйн чиглэлээр

Тус аймгийн 13 сум 90 багт 2,190,000 толгой мал өвөлжиж байна. 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хорогдол, хээл хаялт гараагүй мал аж ахуйн өвөлжилт хэвийн явагдаж байна.

2020 оны 1 дүгээр сарын байдлаар Ховд аймгийн Мөнххайрхан сумд 121 өрхийн 29600 толгой малыг тавиулаар, 4 өрхийн 5100 толгой мал өөрсдөө хошоор оторлож байна. Дуут сумд 18 өрхийн 9619 толгой мал оторлож байгаагаас 5200 нь толгой малыг 8 малчин өөрсдөө хошоор очиж маллаж байна. Үлдсэн 4219 мал тухайн сумдын малчдад тавиулаар оторлож байна. Дэлүүн сумын Хөх сэрхийн нуруунд 15

өрхийн 22700 толгой мал отроор, 3900 толгой мал тавиулаар оторлож байна. Бүгд Булган сумаас 65819 толгой мал оторлож байна. Ногооннуур сумын 18 өрхийн 3500 адуу, 200 үхэр Увс аймгийн Бөхмөрөн сумын Нуурын мухар гэдэг газарт отороор өвөлжиж байна. Нийтдээ аймгийн хэмжээнд 172 өрхийн 69519 толгой мал отроор өвөлжүүлж байна. Баяннуур, Цэнгэл, Улаанхус сумын зарим багийн малууд сум дотроо отор хийж байна.

2020 оны 1-р сарын 9-ний өдөр бүх сумын нутагт бага зэргийн цас орсон. Өнөөдрийн байдлаар шөнөдөө 27° - 33° С хүйтэн, өдөртөө 18° - 25° С хүйтэн байна. Алтай, Сагсай, Дэлүүн, Цэнгэл сумдын нутгаар цасны зузаан 2-6 см, бусад сумдын нутгаар 0,13-1 см цастай байна.

Он гараад аймгийн Өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс Булган сумд 60,0 тн өвс шилжүүлэн байршуулсан ба “Шыбар харага”н ХХК-иас 1000 боодол өвс нэмж авсан болно.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

Энэ сард 2019 оны жилийн эцсийн тайлан тооцоог гаргах ажлыг гүйцэтгэж, сумдад албан бичгээр үүрэг чиглэл өгч, орон нутгийн хөгжлийн сангийн тайлан хүлээн авах, нэгтгэх, орон нутгийн хөгжлийн индекс тооцох үзүүлэлтийг хүлээн авах, нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.

2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангах зорилгоор Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Барилга захиалагчийн албатай хамтран хурлыг зохион байгуулж, үүрэг чиглэл өгч, аймгийн Засаг даргын захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, засварын ажлын захиалагчаар ГХБХБГ-ыг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, зааврын ажлын захиалагчаар Барилга захиалагчийн албыг томилон ажиллаж байна. 2020 оны худалдан авах ажиллагааны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж хүргүүлэн ажилласан.

5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг ХАСХОМ-ийн мэдээллийн санд оруулан баталгаажуулав.

Байгууллагын төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн програмд оруулах ажлыг гүйцэтгэлээ.

2019 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн төслийн баримт бичгүүдийг яамны байгаль орчин нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний мэдээллийн санд оруулж байна.

Усны болон амьтны тухай хууль тогтоомжуудыг орон нутгийн хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг зохион байгууллаа.

2 иргэн, 1 аж ахуйн нэгжийн төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж хүргүүлээ.

Газрын төрийн үйлчилгээний албан хаагчид 2020 оны хөдөлмөрийн гэрээ байгууллаа.

Сумдын 2019 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд хийсэн ажлыг тодорхой үзүүлэлтээр дүгнэв.

2020 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны дээд хязгаарыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд оруулан батлуулав.

Улаанбаатар хотод БОАЖЯам, Үндэсний статистикийн хороо, хамтран Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр зохион байгуулсан Шинэчлэн батлагдсан “БОХ” маягт, тэдгээрийг нөхөх заавар, байгаль орчны статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг анхан шатны мэдээ, мэдээлэл цуглуулагчдад танилцуулах сургалтад хариуцсан мэргэжилтэн, ойн ангийн нэг мэргэжилтэн 5 байгаль хамгаалагч нарыг оролцууллаа.

Улаанхус, Дэлүүн сумуудын төвийн нэгдсэн халаалт болон Өлгий сумын “Мунказ” авто угаалгын 2020 оны ус ашиглуулах дүгнэлтийг тус тус гаргаж хүргүүлэв.

Өлгий сумын ЗДТГазртай хамтран Өлгий сумын нутаг дэвсгэрт үйлдвэр, үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, Усны тухай хууль тогтоомж дүрэм журмуудын хэрэгжилтийг хангуулах, шалган сурталчлах ажлуудыг зохион байгууллаа.

Нэн ховор, ховор ан амьтдын байршил нутгуудад биотехникийн арга хэмжээ авч ажиллаж байна.

5.3. Газрын харилцааны чиглэлээр

Энэ сард 2019 оны эдэлбэр газрын нэгдмэл сангийн тайланг нэгтгэж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.

Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар “Өмчлүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт оруулан 17 иргэнд 14554 м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх, 1127 м² газарт нийтийн орон сууц барьж ашиглалтад оруулсан тул нийтийн эдэлбэрт шилжүүлэх тухай, *ᠠᠨᠠᠵᠠᠳ ᠤᠰᠤᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠠᠵᠠᠳ ᠠᠨᠠᠵᠠᠳ ᠠᠨᠠᠵᠠᠳ* хэсэгчлэн шилжүүлж, газар эзэмшүүлэх тухай, Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 38 иргэнд 33559 м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх тухай шийдвэрүүдийг тус тус гаргалаа.

5.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Салбаруудын холбогдох мэдээ, судалгаа, тайланд хяналт-шалгалт хийж зохих газруудад хугацаанд нь хүргүүлэв.

Төвийн вэб сайтад холбогдох мэдээ, мэдээллийг байршуулав.

Сумдад 3 удаа зааварчилгаа явуулсан ба тус сард 5 албан тоот боловсруулан гаргасан.

Цаг агаарын урьдчилсан мэдээний талаар аймгийн радио болон телевизэд ярилцалга өгөв.

2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээг холбогдох газруудад болон сумын өртөө, харуулуудад цахим хэлбэрээр хүргүүлэв.